

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
20 19 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн
19/04 тоот тогтоолын хавсралт



ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилго

Энэхүү бодлогын зорилго нь компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, менежментийн баг болон компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход оршино.

1.2. Холбогдох баримт бичиг

- 1.2.1. Монгол Улсын Компанийн тухай хууль;
- 1.2.2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль;
- 1.2.3. Компанийн Дүрэм;
- 1.2.4. Санхүүгийн Зохицуулах Хорооны баталсан Монголын Компанийн Засаглалын Кодекс;
- 1.2.5. Холбогдох бусад эрх зүйн акт

1.3. Нэр томъёоны тодорхойлолт

“Гүйцэтгэх удирдлага” гэж Гүйцэтгэх захирлыг ойлгоно.

“Компани” гэж АПУ Хувьцаат компанийг ойлгоно. Үүнд АПУ нэгдлийн оролцогч компаниуд багтана.

“Менежментийн баг” гэж чиглэл эрхэлсэн захирлуудыг ойлгоно. Үүнд АПУ нэгдлийн оролцогч компаниудын Гүйцэтгэх захирлууд багтана.

“ТУЗ” гэж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ойлгоно.

1.4. Зарчим

Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоондоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 1.4.1. Бизнесийн стратегитай уялдуулах: Бид урт хугацааны өсөлтийг бий болгож, хувьцаа эзэмшигчдэд хүртээх ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнесийн стратегитайгаа цалин урамшууллын тогтолцоогоо уялдуулна.
- 1.4.2. Өрсөлдөхүйц байх: Бид мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг сонгон шалгаруулж, тогтвор суурьшилтай ажиллуулахад шаардлагатай цалин урамшууллын тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 1.4.3. Гүйцэтгэлд суурилах: Бид тодорхой, хэмжигдэхүйц зорилго тавьж, гүйцэтгэлийг шударгаар үнэлэн урамшуулал олгоно.
- 1.4.4. Хүний хөгжилд анхаарах: Бид ажилтнуудын карьерийн ахиц дэвшил, хувь хүний хөгжилд анхаарч, албан тушаал дэвших, тасралтгүй суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Хоёр. ТУЗ-ийн цалин, урамшуулал

- 2.1. ТУЗ-ийн гишүүн нь тогтмол үндсэн цалин хөлстэй байна. Энэхүү цалин хөлс нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвараа дайчлан ажиллах, гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн байна.
- 2.2. ТУЗ-ийн гишүүнд үндсэн цалин хөлснөөс гадна дараах хэлбэрийн нэмэгдэл цалин хөлс, урамшууллыг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр олгож болно. Үүнд:
 - 2.2.1. Хуралд ирсэн тохиолдол бүрд;
 - 2.2.2. Хурал даргалах цалин;
 - 2.2.3. ТУЗ-ийг удирдах цалин;
 - 2.2.4. Хараат бус гишүүний нэмэгдэл хөлс;
 - 2.2.5. Компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулал цалин;
 - 2.2.6. Хорооны үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд олгох цалин;
 - 2.2.7. Бусад урамшуулал, шагнал.
- 2.3. ТУЗ-н гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх системийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо ба/эсвэл Цалин урамшууллын хороо боловсруулж, батлан мөрдөх бөгөөд тайлангийн жил дууссаны дараа гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоож болно.
- 2.4. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн ажлын албаны ажилтнуудын цалинг ТУЗ тогтооно.

Гурав. Гүйцэтгэх удирдлага, Менежментийн багийн цалин урамшуулал

- 3.1. Гүйцэтгэх удирдлага болон Менежментийн багийн гишүүдийн цалин хөлсний бүрдэл нь үндсэн цалин болон урамшууллаас бүрдсэн байна.
- 3.2. Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох системийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо ба/эсвэл Цалин урамшууллын хороо боловсруулж, батлан мөрдөнө.
- 3.3. Менежментийн багийн гишүүдийн ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх удирдлага үнэлгээ өгч дүгнэн, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох шийдвэрийг энэхүү бодлого, зарчимд нийцүүлэн гаргана..

Дөрөв. Компанийн ажилтны цалин, урамшуулал

- 4.1. Энэхүү бодлого, зарчимд нийцүүлж, Компанийн нийт ажилтны цалин урамшууллыг Гүйцэтгэх удирдлага тогтооно.
- 4.2. Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд энэхүү бодлого, зарчимд нийцүүлэн Гүйцэтгэх удирдлагаас цалин хөлс, урамшууллыг шинэчлэн тогтоож болно.

Тав. Хяналт, сайжруулалт

- 5.1. Энэхүү бодлогын баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрчилж, сайжруулж, хүчингүй болгож болно.
- 5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо хяналт тавьж ажиллана.